



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/30/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Аудитор: Б.Мөнхбамбар Утас: 70512127</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
5.1 Төлбөрийн акт	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

Ааб. О.Д. Ач № 73

танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН НАРАН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Э.ЗУЛЦЭЦЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын Тамгын газар нь төрийн албан хаагчдын цалингийн нэгдсэн системд бүрэн нэвтэрч, төрийн сангийн ажил гүйлгээг цахим болох бэлтгэл ажлын ханган ажиллаж байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын Тамгын газрын 2022 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 7 зорилт, 26 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 95.3 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>41,978,645.01</u>	<u>97,159,485.01</u>
33	АВЛАГА	7,392,500.00	5,000,000.00
335	Бусад авлага	7,392,500.00	5,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	2,392,500.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	5,000,000.00	5,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	34,586,145.01	92,159,485.01
354	Хангамжийн материал	26,376,145.01	34,339,485.01
35410	Бичиг хэргийн материал	382,500.00	667,500.00
35420	Аж ахуйн материал	12,927,945.01	33,671,985.01
35430	Сэлбэг хэрэгсэл	13,065,700.00	00.00
35600	Мал амьтад	8,210,000.00	57,820,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>541,075,707.64</u>	<u>811,801,943.76</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	541,075,707.64	811,801,943.76
392	Биет хөрөнгө	539,415,707.64	808,146,943.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	161,953,506.00	161,953,506.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-47,387,115.51	-52,095,857.01
39203	Авто-тээврийн хэрэгсэл	212,504,800.00	178,460,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-150,665,701.54	-117,487,048.22
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	47,118,658.30	42,074,683.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-36,967,449.46	-13,587,256.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	49,249,697.77	53,511,916.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,431,130.76	-20,520,401.91
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	15,372.00	15,372.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	487,263,835.00	587,160,228.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-144,238,764.16	-106,138,198.26
39216	Дуусаагүй барилга, байгууламж	00.00	94,800,000.00
393	Биет бус хөрөнгө	1,660,000.00	3,655,000.00
39301	Програм хангамж	400,000.00	2,395,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-400,000.00	-400,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,660,000.00	1,660,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>583,054,352.65</u>	<u>908,961,428.77</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>583,054,352.65</u>	<u>908,961,428.77</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	583054352.65	908961428.77
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	242,206,405.60	242,206,405.60
51101	Өмч: - төрийн	242,206,405.60	242,206,405.60
512	Хуримтлагдсан үр дүн	284,242,512.61	612,278,888.73
51210	Өмнөх үеийн үр дүн	284,242,512.61	286,371,812.61
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	325,907,076.12

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,605,434.44	54,476,134.44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	583,054,352.65	908,961,428.77

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	582,759,236.50	875,991,779.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	155,904,760.00	335,945,331.00
120	Нийтлэг татварын бус орлого	155,904,760.00	335,945,331.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	153,512,260.00	335,945,331.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,742,900.00	1,537,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	151,769,360.00	334,407,731.00
120009	Бусад орлого	2,392,500.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	426,854,476.50	540,046,448.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	385,567,300.00	425,419,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	385,567,300.00	425,419,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,287,176.50	114,626,648.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,274,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,805,426.50	2,107,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	24,207,750.00	112,519,148.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	493,326,387.63	550,084,702.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	493,326,387.63	550,084,702.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	456,702,143.24	477,023,579.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,197,257.54	203,835,974.94
210101	Үндсэн цалин	152,636,947.39	153,325,298.72
210102	Нэмэгдэл	36,768,425.51	27,594,732.62
210104	Урамшуулал	00.00	8,641,482.40
210105	Гэрээт ажлын хөлс	17,791,884.64	14,274,461.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,543,350.94	26,699,889.57
210201	Тэтгэврийн даатгал	17,996,620.74	18,416,847.32
210202	Тэтгэмжийн даатгал	2,279,936.96	2,269,366.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,568,878.36	1,630,702.97
210204	Ажилгүйдлийн даатгал	416,777.91	398,362.32
210205	Эрүүл мэндийн даатгал	4,281,136.97	3,984,610.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,401,801.30	23,241,258.28
210301	Гэрэл, цахилгаан	5,459,963.10	5,765,323.57
210302	Түлш, халаалт	15,544,238.20	10,918,134.71
210303	Цэвэр, бохир ус	18,397,600.00	6,557,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,360,084.00	46,145,230.00

210401	Бичиг хэрэг	1,885,700.00	2,197,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,184,510.00	22,091,040.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,234,074.00	3,363,530.00
210404	Ном, хэвлэл	00.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,055,800.00	500,000.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	16,993,660.00
2105	Нормативт зардал	00.00	210,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	210,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,946,480.00	19,085,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	5,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,100,200.00
210604	Урсгал засвар	6,946,480.00	12,985,700.00
2107	Томилолт, зочны зардал	5,659,000.00	9,389,000.00
210702	Дотоод албан томилолт	5,659,000.00	9,389,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,589,257.00	39,111,092.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,278,460.00	37,956,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170,325.00	170,325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	390,000.00
210807	Газрын төлбөр	21,122.00	79,417.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	451,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,004,912.46	109,305,234.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	35,284,855.00	72,598,740.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,264,000.00	1,360,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	71,456,057.46	35,346,494.88
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,624,244.39	73,061,123.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,779,420.00	25,709,180.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,704,720.00	5,712,980.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	8,368,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,273,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	801,000.00	11,627,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,844,824.39	47,351,943.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,844,824.39	47,351,943.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	89,432,848.87	325,907,076.12
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,530,138.80	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,530,138.80	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,530,138.80	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	86,902,710.07	325,907,076.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>429,921,530.17</u>	<u>543,976,548.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,459,553.67	1,537,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,459,553.67	1,537,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,742,900.00	1,537,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,742,900.00	1,537,600.00
120009	Бусад орлого	3,716,653.67	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	424,461,976.50	542,438,948.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	385,567,300.00	425,419,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	385,567,300.00	425,419,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,894,676.50	117,019,148.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,274,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,805,426.50	4,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,815,250.00	112,519,148.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>429,041,530.17</u>	<u>520,731,548.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	429,041,530.17	520,731,548.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	392,417,285.78	447,670,414.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,197,257.54	203,835,974.94
210101	Үндсэн цалин	152,636,947.39	154,735,875.49
210102	Нэмэгдэл	36,768,425.51	26,184,155.85
210104	Урамшуулал	00.00	8,641,482.40
210105	Гэрээт ажлын хөлс	17,791,884.64	14,274,461.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,543,350.94	26,699,879.57
210201	Тэтгэврийн даатгал	17,996,620.74	18,416,847.32
210202	Тэтгэмжийн даатгал	2,144,484.33	2,269,366.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,704,330.99	1,630,692.97
210204	Ажилгүйдлийн даатгал	420,932.91	398,362.32
210205	Эрүүл мэндийн даатгал	4,276,981.97	3,984,610.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,411,801.30	23,241,258.28
210301	Гэрэл, цахилгаан	5,459,963.10	5,765,323.57
210302	Түлш, халаалт	19,554,238.20	10,918,134.71
210303	Цэвэр, бохир ус	18,397,600.00	6,557,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,804,034.00	30,054,570.00
210401	Бичиг хэрэг	3,116,200.00	3,100,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,289,460.00	22,091,040.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,509,074.00	3,363,530.00
210404	Ном, хэвлэл	00.00	1,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	889,300.00	500,000.00
2105	Нормативт зардал	166,500.00	750,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	166,500.00	750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,746,480.00	21,715,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	250,000.00	5,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,100,200.00
210604	Урсгал засвар	12,496,480.00	15,615,700.00
2107	Томилолт, зочны зардал	5,659,000.00	9,389,000.00
210702	Дотоод албан томилолт	5,659,000.00	9,389,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,381,257.00	59,103,092.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,070,460.00	57,948,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	64,350.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170,325.00	170,325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	390,000.00
210807	Газрын төлбөр	21,122.00	79,417.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	451,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,507,605.00	72,880,740.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,210,605.00	71,380,740.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,297,000.00	1,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,624,244.39	73,061,133.11
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,779,420.00	25,709,190.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,704,720.00	5,712,990.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	8,368,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,273,700.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	801,000.00	11,627,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,844,824.39	47,351,943.11
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,844,824.39	47,351,943.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>880,000.00</u>	<u>23,245,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>880,000.00</u>	<u>23,245,000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>880,000.00</u>	<u>23,245,000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	<u>880,000.00</u>	<u>23,245,000.00</u>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	880,000.00	23,245,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-880,000.00</u>	<u>-23,245,000.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2010 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	242,206,405.60	62,930,781.44	193,764,455.54	00.00	498,901,642.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,275,347.00	00.00	2,275,347.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	242,206,405.60	62,930,781.44	196,039,802.54	00.00	501,176,989.58
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	86,902,710.07	00.00	86,902,710.07
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	242,206,405.60	56,605,434.44	284,242,512.61	00.00	583,054,352.65
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	242,206,405.60	56,605,434.44	284,242,512.61	00.00	583,054,352.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	2,129,300.00	00.00	2,129,300.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	242,206,405.60	56,605,434.44	286,371,812.61	00.00	585,183,652.65
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-2,129,300.00	00.00	00.00	-2,129,300.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайланг үеийн үр дүн	00.00	00.00	325,907,076.12	00.00	325,907,076.12
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	242,206,405.60	54,476,134.44	612,278,888.73	00.00	908,961,428.77

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	423,419,800.00	379,952,995.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	423,419,800.00	379,952,995.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	404,709,600.00	361,243,205.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	233,963,900.00	203,835,974.94
210101	Үндсэн цалин	158,766,300.00	154,735,875.49
210102	Нэмэгдэл	36,141,100.00	26,184,155.85
210104	Урамшуулал	8,466,400.00	8,641,482.40
210105	Гэрээт ажлын хөлс	30,590,100.00	14,274,461.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,245,500.00	26,699,879.57
210201	Тэтгэврийн даатгал	19,886,900.00	18,416,847.32
210202	Тэтгэмжийн даатгал	2,339,600.00	2,269,366.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,871,800.00	1,630,692.97
210204	Ажилгүйдлийн даатгал	467,900.00	398,362.32
210205	Эрүүл мэндийн даатгал	4,679,300.00	3,984,610.07
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,109,000.00	16,250,579.28
210301	Гэрэл, цахилгаан	4,740,000.00	4,739,944.57
210302	Түлш, халаалт	19,769,000.00	10,918,134.71
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	592,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,140,000.00	20,916,430.00
210401	Бичиг хэрэг	3,100,000.00	3,100,000.00
210402	Тээвэр, шатахуун	14,000,000.00	13,992,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,540,000.00	3,323,530.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	500,000.00

2105	Нормативт зардал	750,000.00	750,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	750,000.00	750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,700,200.00	13,700,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,600,000.00	9,600,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100,200.00	1,100,200.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,600,000.00	7,569,000.00
210702	Дотоод албан томилолт	7,600,000.00	7,569,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,601,000.00	7,140,052.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000.00	3,989,960.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.00	170,325.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,391,000.00	2,385,000.00
210807	Газрын төлбөр	110,000.00	79,417.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	451,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64600000.00	64381090.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,100,000.00	62,881,090.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00	1,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18710200.00	18709790.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,710,200.00	18,709,790.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	5,713,400.00	5,712,990.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,368,600.00	8,368,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,628,200.00	4,628,200.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	423,419,800.00	379,952,995.89
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	423,419,800.00	379,895,395.89
131001	Улсын төсвөөс санхүүжих	423,419,800.00	379,895,395.89
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	57,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	57,600.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	23.00
620001	Удирдах ажилтан	06.00	06.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08.00	08.00
620003	Үйлчлэх ажилтан	09.00	09.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын Тамгын газар “Сум орон нутгийн хөгжил дэвшлийг хангаж нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, төрийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээг иргэн бүрт ил тод, жигд хүртээмжтэй хүргэх” эрхэм зорилгын хүрээнд сумын нийгэм эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн оновчтой бодлого, нийгмийн салбарын хөгжлийг ахиулахад дэмжлэг үзүүлэх зорилго, үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 325,907.0 мянган төгрөгөөр буюу 35.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	7,392.50	5,000.0	-2,392.50
Бараа материал	34,586.10	92,159.50	57,573.40
Үндсэн хөрөнгө	541,075.70	811,801.90	270,726.20
Нийт хөрөнгө	583,054.30	908,961.40	325,907.10
Өр төлбөр	0	0	0.00
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	583,054.40	908,961.40	325,907.00
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	583,054.40	908,961.40	325,907.00

- Авлагын данс 2,392.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагын үлдэгдэл барагдсан нь нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө данс 811,801.9 мянган төгрөг болж 270,726.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, үнэ төлбөргүй 185,396.4 мянга, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 23,245.0 мянга, шилжүүлж авсан 97,431.3 мянга нийт 306,072.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 15,782.9 мянган төгрөг хөрөнгийг акталж, 128,424.9 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлж, хөрөнгийн элэгдлээр буурсан нөлөөлсөн байна.
- Засгийн газрын хувь оролцоо данс 325,907.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 461,818.9 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс орон төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 423,419.8 мянга төгрөг батлагдсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг орон нутгийн санхүүжилт 425,419.8 мянган төгрөгөөр төсөв батлагдсанаас 379,953.0 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн санхүүжилт 425,419.8 мянга, туслах үйл ажиллагааны орлого 57.6 мянга, нийт 425,477.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн санхүүжилтээс 45,524.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 379,953.0 мянган төгрөг буюу 89.3 хувьтай зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101-Үндсэн үйл ажиллагаа	303,968.5	264,912.8	39,055.7	87%

2	80106-Баг, хорооны үйл ажиллагааны зардал	35,741.1	31,558.8	4,182.3	88%
3	80714-Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	5,713.4	5,713.0	0.4	100%
4	80802-ажил олгогчоос олгох тэтгэмж	12,996.8	12,996.8	0.0	100%
5	81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	7,000.0	4,944.8	2,055.2	71%
6	81518-Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зардал	50,000.0	49,923.2	76.8	100%
7	82201-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	6,000.0	5,913.6	86.4	99%
8	82706-Гоц халдварт өвчний голомтын буруулах, тархалтыг багасгах	4,000.0	3,990.0	10.0	100%
НИЙТ		425,419.8	379,953.0	45,466.8	

Тус газар нь орон тоо дутуу ажилласан, ЗДТГ-ын байр нэгдсэн халаалтад холбогдсоноос гэрээт ажилтан нарын цалингийн зардал хэмнэгдсэн нь нөлөөлсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 4,5000 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 112,519.1 мянга, нийт 117,091.1 мянган төгрөгийн орлого төвлөрч гүйцэтгэлээр 115,191.6 мянган төгрөгийг зарцуулж 1,899.5 мянган төгрөгийг дээд шатны төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг авч үзвэл байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6,990.7 мянга, хангамж, бараа материалын зардалд 9,138.1 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 24,915.7 мянга, томилолт, зочны зардалд 1,820.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 53,958.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 12,849.7 мянга нийт 116,671.6 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 550,084.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 11,001.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 16,160.6 мянган төгрөгөөр буурсан, бичиг хэрэг, тээвэр шатахууны зардал 7,217.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Дээрх зардал өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Тээвэр шатахуун, бичиг хэргийн зардал: Шатах тослох материал, бичиг хэргийн материалын үнэ өмнөх оноос дунжаар 52.0 хувиар нэмэгдсэн нь гол нөлөөлөл үзүүлсэн байна.*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гаргасан тушаал шийдвэр, орлого зарлагын мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Наран сумын Засаг даргын Тамгын газард завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	100
Зөвлөмж	1	-	1	-	100
Нийт дүн	2	-	2	-	100

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,072.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,072.0 мянган төгрөгийн зөрчил³ илэрч төлбөрийн акт тогтоолоо.

5.1 Төлбөрийн акт

Бараа үйлчилгээний бусад зардлаас албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчдад 1,072.6 төгрөгийн хоол хүнсний материал худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн 6.4.1 /Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дугаар зүйлийн 9.3⁴ /Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно./-т заасныг тус тус зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

³ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

⁴ Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:

